**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор аймгийн Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2025.03.15 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Г.Энхзул<br>Утас: 99333147 Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН** ..... 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 11
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 13
**4.1 Ерөнхий зүйл** ..... 13
**4.2 Материаллаг байдал** ..... 13
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 14
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 14
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 14
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 14
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 14
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.02.15 № 2/86

танай__________-ны № __________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛТАЙ
АМЬДРАЛ СЭТГЭЦ НИЙГМИЙН
СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА А.ОРХОНЧИМЭГ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

5020410

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 99.8 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **27,530,477.41** | **28,674,248.64** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1,651,309.61 | 22,513,795.88 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 1,651,309.61 | 22,513,795.88 |
| **3121** | **Төгрөг** | 1,651,309.61 | 22,513,795.88 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,651,309.61 | 22,513,795.88 |
| **33** | **АВЛАГА** | 10,385,517.00 | 838,853.96 |
| **335** | **Бусад авлага** | 10,385,517.00 | 838,853.96 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 838,853.96 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 10,385,517.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 15,493,650.80 | 5,321,598.80 |
| **351** | **Түүхий эд материал** | 14,852,650.80 | 1,370,690.80 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 14,073,600.00 | 00.00 |
| 35130 | Эм боох материал | 779,050.80 | 1,370,690.80 |
| **354** | **Хангамжийн материал** | 641,000.00 | 3,950,908.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 120,000.00 | 566,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 521,000.00 | 2,322,809.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 1,061,599.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **15,569,876.76** | **44,503,792.52** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 15,569,876.76 | 44,503,792.52 |
| **392** | **Биет хөрөнгө** | 15,070,243.13 | 44,068,658.89 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 8,399,100.00 | 19,145,000.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (3,875,849.72) | (6,643,943.90) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,474,700.00 | 45,242,600.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,927,707.15) | (13,674,997.21) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 499,633.63 | 435,133.63 |
| 39301 | Программ хангамж | 774,000.00 | 774,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (274,366.37) | (338,866.37) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **43,100,354.17** | **73,178,041.16** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **22,605,136.17** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 22,605,136.17 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 22,605,136.17 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 2,119,109.17 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 9,262,091.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 11,223,936.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 11,223,936.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **20,495,218.00** | **73,178,041.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 20,495,218.00 | 73,178,041.16 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 20,495,218.00 | 73,178,041.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 20,495,218.00 | 20,495,218.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 52,682,823.16 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **43,100,354.17** | **73,178,041.16** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **100,000,000.00** | **300,709,190.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **30,709,190.70** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 29,829,190.70 |
| 120002 | Хүүгийн орлого | 00.00 | 206,010.70 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 28,657,225.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 6,803,325.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 21,853,900.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 965,955.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 880,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 880,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **100,000,000.00** | **270,000,000.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 100,000,000.00 | 270,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 100,000,000.00 | 270,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **132,989,873.88** | **247,906,850.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **132,989,873.88** | **247,906,850.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 132,989,873.88 | 247,906,850.54 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 69,686,294.00 | 150,244,965.74 |
| 210101 | Үндсэн цалин | 69,641,294.00 | 150,244,965.74 |
| 210104 | Урамшуулал | 45,000.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 7,975,818.19 | 14,666,563.53 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,975,818.19 | 14,553,833.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 112,730.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,990,381.00 | 17,746,055.66 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,645,430.00 | 2,487,741.66 |
| 210302 | Түлш, халаалт | 3,368,111.00 | 11,675,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 976,840.00 | 3,582,414.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,594,439.00 | 12,997,140.22 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,409,025.00 | 1,584,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,413,000.00 | 1,319,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 542,904.00 | 2,010,999.22 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 598,750.00 | 6,859,806.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,630,760.00 | 1,223,085.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 37,899,131.00 | 24,384,979.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 17,800,131.00 | 10,146,958.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,099,000.00 | 13,518,021.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 720,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,500,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 2,500,000.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 4,019,448.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 4,019,448.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 332,395.00 | 18,812,814.15 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 308,000.00 | 17,724,013.09 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,007,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 24,395.00 | 81,801.06 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,011,415.69 | 5,034,884.24 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,011,415.69 | 5,034,884.24 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(32,989,873.88)** | **52,802,340.16** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 119,517.00 |
| 225002 | Найдваргүй авлагын алдагдал | 00.00 | 119,517.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | (119,517.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(32,989,873.88)** | **52,682,823.16** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **100,000,000.00** | **289,121,290.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **19,121,290.70** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 18,241,290.70 |
| 120002 | Хүүгийн орлого | 00.00 | 206,010.70 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 6,803,325.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 6,803,325.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 11,231,955.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 880,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 880,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **100,000,000.00** | **270,000,000.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 100,000,000.00 | 270,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 100,000,000.00 | 270,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **214,027,532.97** | **254,689,004.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **214,027,532.97** | **254,689,004.43** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **205,301,627.64** | **254,689,004.43** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 132,588,675.08 | 153,467,001.40 |
| 210101 | Үндсэн цалин | 132,543,675.08 | 153,467,001.40 |
| 210104 | Урамшуулал | 45,000.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 8,096,278.00 | 14,402,491.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,566,975.00 | 14,289,761.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,529,303.00 | 112,730.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 7,994,750.56 | 29,735,692.66 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,993,079.56 | 2,487,741.66 |
| 210302 | Түлш, халаалт | 3,368,111.00 | 20,937,991.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,633,560.00 | 6,309,960.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,154,114.00 | 15,113,384.22 |
| 210401 | Бичиг хэрэг | 622,700.00 | 3,109,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,543,000.00 | 1,319,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,026,904.00 | 2,181,499.22 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,561,660.00 | 4,007,829.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,399,850.00 | 4,495,806.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 43,046,940.00 | 33,065,773.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,645,940.00 | 17,806,964.00 |
| 210502 | Хоол, хүнс | 23,401,000.00 | 14,538,809.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 720,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,500,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 2,500,000.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 4,019,448.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 4,019,448.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 534,395.00 | 4,885,214.15 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 510,000.00 | 3,749,513.09 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,052,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 24,395.00 | 83,701.06 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 386,475.00 | 00.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 386,475.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,725,905.33** | **00.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,725,905.33 | 00.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 8,725,905.33 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(114,027,532.97)** | **34,432,286.27** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **13,569,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **13,569,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 13,569,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 13,569,800.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **(13,569,800.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (114,027,532.97) | 20,862,486.27 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 78,842.58 | 1,651,309.61 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,651,309.61 | 22,513,795.88 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **20,495,218.00** | **00.00** | 20,495,218.00 |
| D01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **20,495,218.00** | **00.00** | 20,495,218.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **20,495,218.00** | **00.00** | 20,495,218.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 52,682,823.16 | 00.00 | 52,682,823.16 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **73,178,041.16** | **00.00** | 73,178,041.16 |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 270,000,000.00 | 268,986,143.43 | 1,013,856.57 | 99.62 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 270,000,000.00 | 268,986,143.43 | 1,013,856.57 | 99.62 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 270,000,000.00 | 268,969,356.43 | 1,030,643.57 | 99.62 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 152,817,200.00 | 153,467,001.40 | (649,801.40) | 100.43 |
| 210101 | Үндсэн цалин | 152,817,200.00 | 153,467,001.40 | (649,801.40) | 100.43 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,939,700.00 | 14,402,491.00 | 2,537,209.00 | 85.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,939,700.00 | 14,289,761.00 | 2,649,939.00 | 84.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 112,730.00 | (112,730.00) | 0.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,449,005.00 | 29,735,692.66 | 1,713,312.34 | 94.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,440,000.00 | 2,487,741.66 | (47,741.66) | 101.96 |
| 210302 | Түлш, халаалт | 23,464,005.00 | 20,937,991.00 | 2,526,014.00 | 89.23 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,545,000.00 | 6,309,960.00 | (764,960.00) | 113.80 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,376,195.00 | 16,224,284.22 | 5,151,910.78 | 75.90 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,483,100.00 | 3,109,250.00 | 373,850.00 | 89.27 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,230,000.00 | 1,319,000.00 | 911,000.00 | 59.15 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,580,000.00 | 2,181,499.22 | 398,500.78 | 84.55 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,740,000.00 | 5,118,729.00 | (378,729.00) | 107.99 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 8,343,095.00 | 4,495,806.00 | 3,847,289.00 | 53.89 |
| **2105** | **Нормативт зардал** | 32,300,000.00 | 33,445,773.00 | (1,145,773.00) | 103.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 17,400,000.00 | 18,186,964.00 | (786,964.00) | 104.52 |
| 210502 | Хоол, хүнс | 14,900,000.00 | 14,538,809.00 | 361,191.00 | 97.58 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 720,000.00 | (720,000.00) | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 12,078,900.00 | (12,078,900.00) | 0.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 5,044,000.00 | (5,044,000.00) | 0.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 7,034,900.00 | (7,034,900.00) | 0.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,198,000.00 | 4,730,000.00 | (532,000.00) | 112.67 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,198,000.00 | 4,730,000.00 | (532,000.00) | 112.67 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,919,900.00 | 4,885,214.15 | 6,034,685.85 | 44.74 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,919,900.00 | 3,749,513.09 | 7,170,386.91 | 34.34 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,052,000.00 | (1,052,000.00) | 0.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 83,701.06 | (83,701.06) | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 16,787.00 | (16,787.00) | 0.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 270,000,000.00 | 277,683,325.00 | (7,683,325.00) | 102.85 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 270,000,000.00 | 270,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 270,000,000.00 | 270,000,000.00 | 0.00 | 100.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 00.00 | 6,803,325.00 | (6,803,325.00) | 0.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 6,803,325.00 | (6,803,325.00) | 0.00 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 00.00 | 880,000.00 | (880,000.00) | 0.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 880,000.00 | (880,000.00) | 0.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 10.00 | 10.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 08.00 | 08.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллага эрхэм зорилгоо "Хүн амыг архи болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хамааралд өртөх, зан үйлийн хүрээний донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх, зорилтот бүлгийг эрт илрүүлэх, энэхүү эмгэгт өртсөн хүмүүст эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үндэсний жишигт нийцүүлэн хүртээмжтэй хүргэх" гэж тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Баянхонгор аймгийн Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн даргын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 48 дугаар тушаалаар баталсан " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 73,178.0 мянган төгрөг болж өмнөх оноос 30,077.7 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **27,530.50** | **28,674.20** | **1,143.70** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,651.30 | 22,513.80 | 20,862.50 |
| 33 | АВЛАГА | 10,385.50 | 838.90 | (9,546.60) |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 15,493.60 | 5,321.60 | (10,172.00) |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **15,569.90** | **44,503.80** | **28,933.90** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 15,569.90 | 44,503.80 | 28,933.90 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **43,100.30** | **73,178.00** | **30,077.70** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **22,605.10** | **00.00** | **(22,605.10)** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 22,605.10 | 00.00 | (22,605.10) |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **20,495.20** | **73,178.00** | **52,682.80** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 20,495.20 | 73,178.00 | 52,682.80 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **43,100.50** | **73,178.00** | **30,077.50** |

Авлагын данс эцсийн үлдэгдэл 838.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын хэлтсээс 264.1 мянган төгрөг, татварын хэлтсээс 574.8 мянган төгрөгийн авлагатай байна.

Тус төв нь бараа материалыг аж ахуй, бусад хангамж, бичиг хэрэг, эм боох, хүнсний материал, түлш шатах тослох материал, барилгын засварын материал гэсэн данснуудыг ашиглан гүйлгээ хийдэг бөгөөд 2024 оны жилийн эцэст 5,321.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба хугацаа дууссан, хадгалалтын горим алдагдсан 438.6 мянган төгрөгийн эм тариаг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрээр акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 44,503.8 мянган төгрөг болж 28,933.9 мянган төгрөгөөр өссөн байна. Аймгийн ЗДТГ-аас 2024 оны 11 дүгээр сард 19,370.0 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшил, орон нутгийн төсвөөс байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай 8,595.0 төгрөгийн компьютер, принтер болон бусад тоног төхөөрөмж, 4,973.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг худалдан авч, орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

### 3.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг аймгийн орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 270,000.0 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 20,938.0 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 2,487.7 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 6,309.9 мянган төгрөг РМВ ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-иудтай цахилгаанаар хангах гэрээ тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 270,000.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,050.0 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,835.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд холбогдох заалтуудыг зөрчөөгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 270,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн мэдээлсэн байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж аудитаар 32,990.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 5,278.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 32,990.60 | 1 | 32,990.60 | 100% |
| Албан шаардлага | 3 | 5,278.30 | 3 | 5,278.30 | 100% |
| **Нийт дүн** | **4** | **38,268.90** | **4** | **38,268.90** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

------------oOo-------------